

**СОЁЛЫН ЭРХИЙН БИЧГИЙН ЦОГЦ СИСТЕМИЙГ ХӨГЖҮҮЛЭХ,  
НЭВТРҮҮЛЭХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЖЛЫН ДААЛГАВАР (ЭХНИЙ ҮЕ ШАТ)**

2024 оны 06 дугаар  
сарын ...-ний өдөр

№ .....

Улаанбаатар хот

1	Даалгавар боловсруулах үндэслэл	<ul style="list-style-type: none"> <li>- Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 8.3, 8.4-т Монгол Улсын 16-18 хүртэлх насны иргэнд соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан авах эрхийн бичгийг төрөөс үнэ төлбөргүй олгохоор заасан.</li> <li>- Соёлын эрхийн бичиг нь хүүхэд залуучуудын соёл урлагийн боловсролыг дээшлүүлэх, соёл урлагийн дархлаатай Монгол иргэнийг төлөвшүүлэх, ирээдүйн үзэгчдийг бэлтгэх, соёлын залууст ойртуулах, соёлын илэрхийллийн олон төрлийг таниулна.</li> <li>- Мөн Соёлын салбарыг тэлэх, дэмжих буюу соёлын бүтээлч үйлдвэрлэлийн 12 салбарын байгууллага, аж ахуйн нэгж, хуулийн этгээд болон иргэний уран бүтээл, бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авах замаар эдийн засгийн эргэлтийг дэмжих, цаашид эрхийн бичиг ашигласнаар соёлын боловсролыг дэмжих, хүртээмжийг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулах болно.</li> <li>- Соёлын эрхийн бичгийн үйлчилгээ үзүүлэх арга хэмжээг цахим мэдээллийн системээр дамжуулан хүргэх бөгөөд мэдээллийн аюулгүй байдлыг хангасан, салбарын мэргэжилтнүүд, уран бүтээлчид өсвөр насныханд зориулсан соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, өсвөр насныхныг чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэн, гэмт хэрэг, зөрчил, сөрөг нөлөөллөөс ангид байх нөхцөлийг бүрдүүлнэ.</li> <li>- Мөн амьжиргааны түвшнээс үл хамааран хүүхэд бүр соёл, урлагийн үйлчилгээ авах тэгш хүртээмжийг бүрдүүлж, соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээ, контент бүтээх үйл ажиллагааг идэвхжүүлж, хэрэглээг нэмэгдүүлснээр, эдийн засгийн эргэлт, тогтвортой өсөлтийг дэмжинэ.</li> </ul>
2	Зорилго:	- Өсвөр насны 16-18 насныханд зориулан “Соёлын эрхийн бичгийн цогц систем”-ийн оновчтой загварчлалыг гарган архитектур бүтцийн дагуу системтэйгээр хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлэх.
3	Хамрах хүрээ, агуулга	16-18 насны иргэд буюу эрхийн бичиг ашиглах зорилтот бүлэг, соёлын үзвэр, үйлчилгээ үзүүлэгч байгууллага, хувь хүмүүс, Соёл, урлагийн байгууллагын ажилтан, мэргэжилтэн, админ хэрэглэгч, эцэг эхчүүд, боловсролын

		байгууллагын албан хаагч, багш, нийгмийн ажилтан, санхүүгийн ажилтан, нягтлан бодогч. Соёлын салбарын хэмжээнд ашиглагдахаас гадна бусад холбогдох салбарууд.
4	Захиалагч байгууллага:	Монгол Улсын Соёлын яам
5	Санхүүжилтийн эх үүсвэр:	Улсын төсөв
	Хугацаа:	Гэрээ байгуулснаас хойш 60 хоног
6	Ажил гүйцэтгэлийн даалгавар:	Тендерийн хүрээнд дараах ажлуудыг цогцоор нь гүйцэтгэн нийлүүлэх ба нийт ажлын гүйцэтгэлээр үр дүнг хэмжинэ. Ажлын гүйцэтгэлд дараах ажлуудыг хамруулан ойлгох бөгөөд Agile аргачлалаар хөгжүүлэлтийг хийх. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>• Соёлын эрхийн бичгийн нэгдсэн платформ болон хэрэглэгчийн аппликейшныг хөгжүүлэх, нэвтрүүлэх /Хэрэглэгчдэд зориулсан public web болон гар утасны апп, соёлын эрхийн бичгийн үндсэн систем бүхий бүртгэл, үйл ажиллагааны функцүүдийг агуулсан back office систем/</li> <li>• Соёлын эрхийн бичгийн нэгдсэн системийн эрхийн зохицуулалтыг бүрэн хэрэгжүүлж, хамтрагч талуудын системд оруулах /Одоогийн ашигладаг дотоод болон бусад салбарын системүүдтэй холбогдож ажиллана./</li> </ul>
7	Төслийн хэрэгжүүлэлт: Гүйцэтгэх ажил	Гүйцэтгэгч нь Соёлын эрхийн бичгийн системийг хөгжүүлэх нарийвчилсан хуваарь болон хэрэгжилт, нэвтрүүлэлтийн үеийн дэлгэрэнгүй төлөвлөгөөг ирүүлэх ёстой бөгөөд санал болгож буй модулиудыг үе шат бүрээр оруулах ба туршилт тест тус бүрийн шаардагдах хугацааг сайтар тооцож оруулсан байна. Хэрэгжүүлэх төлөвлөгөөнд суурилуулах, турших, зэрэгцээ болон шууд ажиллуулах үе шатууд, үе шат бүрийн төгсгөлд хийх шалгалтууд, тус бүрээс гарах үр дүнг тусгасан байна.
8	Техникийн шийдлийн тодорхойлолт: Системийн шаардлагатай модулиудыг цогцоор нь хөгжүүлж ашиглалтад оруулсан байна. /Хавсралт 1. Системийн ерөнхий бүтэц модулийн зураглал, Хавсралт 2. Системийн архитектур зураглал /	
№	Модулийн нэр	Тайлбар
8.1	Бүртгэлийн модуль	Иргэд, эцэг эхчүүд, Соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгч, нийгмийн ажилтан, багш, ангийн багш, соёл урлагийн байгууллагын ажилтан, нягтлан бодогч, соёлын яамны админ, мэргэжилтэн гэх мэт системийн үндсэн бүртгэлийг хийдэг байна.
8.2	Системийн тохиргоо, удирдлагын	Соёлын яамны админ болон мэргэжилтэн системийн хэрэглэгчийн эрхийн тохиргоо, соёлын эрхийн бичгийн төрлүүд, түүний санхүүжилт авах хувь, хөтөлбөр,

	модуль/админы модуль	контентын төрөл, категори, урын сан зэрэг мэдээллийг тохируулна.
8.3	Эвент, арга хэмжээний модуль/Үзвэр үйлчилгээний модуль	Үзвэр үйлчилгээний байршил, огноо, хөтөлбөр, бүтээгдэхүүн, үйлчилгээний агуулга, уран бүтээлчийн мэдээлэл, постер, танилцуулгыг удирдан зохион байгуулна.
8.4	Цахим хэтэвч	Иргэнд соёлын бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан авахад зориулсан төлбөрийн нэгжийн төлөөлөх цахим хэтэвч. Эрхийн бичгийн дүнгээр автоматаар цэнэлэгдэх, өсвөр насныхны хувийн хэтэвч буюу хувийн дугаар байна.
8.5	Захиалгын модуль	Хэрэглэгчийн хувьд огноо, байршил, төрөл гэх мэт шалгуураар соёлын хөтөлбөр, контентыг хайж өөрийн хэтэвчинд тааруулан захиалгыг хийнэ. Мөн бусад гуравдагч платформтой холбогдож захиалгуудыг хийж болно.
8.6	Төлбөр тооцооны модуль	Хэрэглэгчийн болон СБҮЭ-ийн дансыг удирдаж, бүтээгдэхүүн, үйлчилгээний төлбөр болон Соёлын яамны данс цэнэглэлтийг хийх боломжтой.
8.7	Хайлт, шүүлт тайлангийн модуль	Шаардлагатай жагсаалт, тайлан мэдээллийг харах ба экселээр өөр нэмэлт форматаар татах боломжтой байна. Бүх төрлийн статистик мэдээлэл гаргах, хөтөлбөрүүдийн үр ашгийг хэмжих, dashboard /Захиалгууд, үнэлгээ, сэтгэгдлүүд, хандалтын тоо, үзэлтийн тоо, санхүүгийн тайлан/ Хэрэглэгчид өөрийн эрхийн хүрээнд хөтөлбөр, контент, захиалга, үзэлт, байршил гэх мэт оруулсан мэдээллээр тайлангаа төрөл бүрээр хардаг байна.
8.8	Тасалбар модуль	QR code уншуулах боломжийг бий болгосон тасалбар. Эрхийн бичгийн хасалтын гүйлгээний мэдээлэл нь энэхүү тасалбартай нягт холбоотой ажиллана.
8.9	Мэдэгдлийн модуль	Хэрэглэгч рүү мэдэгдэл үүсгэн илгээх, мөн хэрэглэгч мэдэгдлийг харах үйл ажиллагааг удирдана.
8.10	Санал гомдол судалгааны модуль	Хэрэглэгч, соёлын байгууллага, эцэг эхчүүд, СБҮЭ нар үйл ажиллагааны дараа санал асуулга бөглөж, санал хүсэлтээ өгдөг байна. Санал хүсэлтийг зохион байгуулах боломжийг олгоно.
9		Системийн хэрэглэгчид: 16-18 насны иргэд буюу эрхийн бичиг ашиглах зорилтот бүлэг, соёлын үзвэр, үйлчилгээ үзүүлэгч байгууллага, хувь хүмүүс, Соёл, урлагийн байгууллагын ажилтан, мэргэжилтэн, админ хэрэглэгч, эцэг эхчүүд, боловсролын байгууллагын албан хаагч, багш, сургуулийн болон хорооны нийгмийн ажилтан, сум багийн ажилтан, санхүүгийн ажилтан, нягтлан бодогч болон бусад салбарын хэрэглэгчид
10	Зөвлөх үйлчилгээ үзүүлэгчид тавих шаардлага	Соёлын яам нь гэрээний хэрэгжилтийн үед ажлын процессын урсгалын мэдээллийг өгөх ба нарийвчилсан эцсийн шаардлагыг өөрчлөх эрхтэй. Тендер зарлагдсанаас хойш ажлын 10 хоногийн дотор гүйцэтгэгчтэй тодруулга авах, тогтсон хуваарийн дагуу тодруулах уулзалт хийх боломжтой. Гүйцэтгэгч нараас санал хүлээж авснаас хойш ажлын 30 ба түүнээс дээш өдрийн хугацаанд сонгон

		шалгаруулалтын процесс хийгдэх ба энэ хугацаанд шаардлагатай гэж үзвэл Гүйцэтгэгчидтэй холбогдон тодруулга хийх болно.
11	Техник хангамжид тавигдах шаардлага:	<ul style="list-style-type: none"> <li>• Серверийн үйл ажиллагаа нь физик сервер, сторэж болон системийн найдвартай ажиллагааг 99.99% хангаж чадахуйц нөөц холболт бүхий шийдлийг санал болгох;</li> <li>• Өгөгдөл, дата нөөцлөлтийн бэлэн байдлыг бүрэн хангах шийдлийг санал болгох;</li> <li>• Соёлын эрхийн бичгийн системийн хатуу болон зөөлөн дэд бүтцийн ажиллагаа доголдсон тохиолдолд нөөцийн тохиргоо хэрхэн хийгдэх, автоматаар шилжих ажиллагааны шийдлийн талаар дэлгэрэнгүй тайлбар ирүүлэх</li> <li>• Хэрэгжүүлэх системийн архитектурын зураглалыг тайлбарын хамтаар ирүүлэх</li> <li>• Өгөгдлийн нөөцийн хадгалалт (backup)-ыг газарзүйн байршлаар өөр байршилд байршуулах шийдлийг санал болгох</li> </ul>
12	Системийн үндсэн шаардлагууд:	<ul style="list-style-type: none"> <li>• Хэрэглэгчийн интерфейс нь Веб, IOS, Android байх</li> <li>• Систем нь Back-office системтэй байх</li> <li>• Системийг хэсэгчилсэн байдлаар уян хатан хэрэгжүүлэх боломжтой байх</li> <li>• Системийн болон серверийн ажиллагаатай холбоотой үйлдлийн систем, дата бааз гм бүх төрлийн лицензийн мэдээллийг саналд тусгана.</li> <li>• Хэрэглэгчийн мэдэлд бүрэн шилжүүлэх системийг нэвтрүүлэх,</li> <li>• Нэмэлт модуль хөгжүүлж өргөтгөх боломжтой байх,</li> <li>• Хэрэгжүүлсэн модулиудад нэмэлт хөгжүүлэлт хийх уян хатан боломжтой байх,</li> <li>• Мэдээллийн системийн төвлөрсөн хандалттай байх</li> <li>• Төлбөр тооцооны шийдлүүдийн хувьд бүх банкны Corporate Gateway үйлчилгээнд холбогдох боломжтой байх</li> <li>• Гуравдагч системүүдтэй холбогдох стандарт API холболт хийх боломжтой байх</li> <li>• Программ хангамжийн хувьд гадаад болон дотоодын мэдээллийн аюулгүй байдлыг бүрэн хангасан байх</li> <li>• Системийн найдвартай ажиллагааг хангаж ажиллах талаар дэлгэрэнгүй мэдээлэл ирүүлэх</li> <li>• Дата баазын найдвартай ажиллагаа, өгөгдөл нөөцлөлтийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл тусгах</li> <li>• Цаашдын ашиглалт үйлчилгээг үзүүлэх боломжтой байх</li> </ul>

		Ашиглалт үйлчилгээний гэрээний хүрээнд системийн хэсэгчилсэн болон алдааны хувилбаруудыг үнэ төлбөргүй шинэчлэл хийх боломжтой байна.
13	Мэдээллийн аюулгүй байдлын шаардлага:	<ul style="list-style-type: none"> <li>• ISO/IEC 27001:2013 олон улсын стандартын дагуу мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог үйл ажиллагаандаа нэвтрүүлэн мөрддөг байх</li> <li>• Дотоод системд холбох нэгдсэн API-тай байх</li> <li>• IPv4 and IPv6 дэмжих боломжтой байх</li> <li>• Систем нь программ хангамжийн аюулгүй байдал, дэд бүтцийн аюулгүй байдал, мэдээллийн сангийн аюулгүй байдлын хяналт, системийн архитектур, сүлжээний сегментчилэл гэх зэрэг аюулгүй байдлын үе шатуудыг дэмждэг байх</li> <li>• Сүлжээний хяналтын төвд төвлөрсөн хяналтад орох боломжтой байх</li> <li>• Систем нь нэгдсэн удирдлага, системийг хянах удирдлагын бүрэлдэхүүнтэй байх,</li> <li>• Өгөгдлийн сангийн нөөцлөх ажил бүтэлгүйтсэн тохиолдолд дохиолол үүсгэдэг байх</li> <li>• Систем нь системийн нөөцийг бүрэн нөөцлөх болон сэргээх функцийг автоматаар болон гараар гүйцэтгэх боломжтой байх</li> <li>• Мэдээллийн системийн оюуны өмчийг Соёлын яам эзэмшинэ.</li> <li>• Системийн бүх эх код (source code)-ийг тайлбарын хамт Соёлын яаманд хүлээлгэн өгнө.</li> </ul>
14	Бусад шаардлага:	- Хэрэглэгч талын үндсэн шаардлагуудыг Хавсралт 3.-т тусгасан.
15	Харилцан холболт хийх системүүд:	<p><i>1. Төрийн үйлчилгээний нэгдсэн системүүд</i></p> <p>Төрийн байгууллагуудын дараах системүүдтэй холбогдон харилцан холболт хийж, үндсэн форматын дагуу тайлан мэдээ болон хэрэглэгчийн мэдээлэл солилцох, зээлийн тооцоо мэдээлэл гаргах боломжтой байх</p> <ul style="list-style-type: none"> <li>- Үндэсний танилт нэвтрэлтийн ДАН систем</li> <li>- Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем</li> <li>- И-Монголиа академи</li> <li>- Багшийн систем <a href="https://bagsh.esis.edu.mn/">https://bagsh.esis.edu.mn/</a></li> <li>- Нийгмийн ажилтны систем</li> <li>- Соёлын яамны санхүүгийн систем</li> <li>- Нийслэлийн соёл урлагийн газар болон үзвэр үйлчилгээний газруудын холбогдох системүүд</li> </ul> <p>2. Сошиал систем, платформ META, TWITTER, ТИКОК, LINKEDIN, INSTAGRAM ГЭХ МЭТ</p> <p>3. Онлайн худалдааны platform-ууд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- SHOPPY.MN</li> <li>- MBOOK</li> <li>- TICKET.MN</li> </ul> <p>4. Соёлын яамны харьяа нэгжүүд</p>


		<ul style="list-style-type: none"> <li>- Нийслэл, орон нутгийн соёл урлагийн нэгжүүд,</li> <li>- Харьяа байгууллагуудын ашигладаг системүүд</li> </ul>
16	Гуравдагч системтэй харилцан холбогдон ажиллах:	<p>Бусад төрийн байгууллагуудын үйл ажиллагааны системүүдтэй харилцан холбогдон ажилладаг байх шаардлагатай.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Харилцан холболтын заагийн цэгийг нарийвчлан тодорхойлж хэрхэн холбогдох талаар саналдаа тусгасан байна.</li> <li>- Харилцан холболт хийж бусад системээс өгөгдөл мэдээллийг оруулах болон нэгтгэсэн өгөгдлийг гаргаж авах боломжтой байна.</li> <li>- Дээрх системүүдтэй холбогдох техникийн холболт нь API холболтоор холбогдох боломжтой байх ба хүсэлтийн түүх болон явцын мэдээллийг цахим сайтад харуулдаг байх шаардлагатай.</li> </ul>
17	Сургалт, туршилт	<ul style="list-style-type: none"> <li>- Хэрэгжүүлэлтийн шаардлагын хүрээнд гүйцэтгэгч нь захиалагчид шаардлагатай туршилт тестийг хийж, мэргэжлийн болон захиалагчийн систем ашиглалтын танхим болон цахим сургалтыг явуулах шаардлагатай.</li> <li>- Төслийн аль үе шатанд, ямар төрлийн сургалтыг хийх талаар тодорхой заасан сургалтын төлөвлөгөөг оруулна.</li> <li>- Мөн үнэ төлбөргүй үзүүлэх сургалтын төрөл, дэмжлэг үзүүлэх ажлын өдрийн тоог зааж өгсөн байна.</li> </ul>
18	Хүлээлгэн өгөх үе шат:	<ul style="list-style-type: none"> <li>- Гэрээ байгуулснаас хойш 30 хоногийн дараа дунд хугацааны тайланг хүлээн авна.</li> <li>- Шаардлагатай туршилт тестийг хийж, сургалтыг зохион байгуулсны дараа хүлээлцэх багийг захиалагч талаас зохион байгуулан эцсийн тайланг албан ёсоор хүлээлцэн баримтжуулна.</li> </ul>

## ХАВСРАЛТ 1

### Системийн архитектур, технологийн шаардлага

Соёлын эрхийн бичгийн системийг хөгжүүлэхдээ ерөнхий бүтэц зохион байгуулалт, архитектурыг дараах зураглалын дагуу баримтална.

Соёлын эрхийн бичгийн системийн ерөнхий бүтцийн зураг




Системийн ерөнхий бүтэц үндсэн 3 хэсгээс бүрдэнэ. Үүнд:

- Хэрэглэгчдэд зориулсан public веб болон гар утасны апп байна.
- Соёлын эрхийн бичгийн үндсэн систем нь бүхий л бүртгэлийн, үйл ажиллагааны функцүүдыг агуулсан back office буюу арын системтэй байна.
- Эдгээрээс гадна Здагч байгууллагууд болон одоогийн ашигладаг дотоод системүүдтэй холбогдож ажиллана. Тэдгээр системүүдтэй мэдээлэл хүлээн авах, дамжуулах үйлдэл rest api -аар холбогдож ажиллана.

Системийн өгөгдөл хадгалах санг нөөцлөлтийг бүрэн хангах шийдлийг санал болгох.

## ХАВСРАЛТ 2. Соёлын эрхийн бичгийн системийн ерөнхий архитектурын зураг



- Ерөнхий архитектур нь модуль бүтэцтэй байх
- Танин баталгаажуулах хэлбэрийг үндэсний танилт нэвтрэлтийн ДАН системээр шийдэх

### Хөгжүүлэх технологийн хувьд:

- Backend system – Python
- Админ хэсгийн веб – JavaScript
- Хэрэглэгчийн аппликэйшн хөгжүүлэлт – Flutter
- Гуравдагч системтэй холбох API – Microservice
- Дата бааз – Postgre байна.

### Эрхийн зохицуулалтын хувьд:

- Хандах эрхийн матрицад 1 хэрэглэгчид 1 эрхийн бүлэгт хамаарагдах
- Эрхийн бүлэг дээр масс өөрчлөлт хийх боломжтой байх /жишээ нь: олон эрхийн бүлгийг сонгож ижил өөрчлөлтийг хийх/
- Эрх олгогдох процесс нь олон шат дамжлагагүй хялбар байх /хэрэглэгч үүсгэж тохируулах хэсэг зөвхөн 1 дэлгэцээр хийгддэг/
- Эрхийн бүлэг хувилах боломжтой байх
- Масс хэрэглэгчийн эрх нээх, хаах, өөрчлөх боломжтой байх
- Эрхийн бүлэг үүсгэж өөрчлөх тохиргоо хялбар байх/хийгдэх үйлдлүүдийг сонгож багцлах боломжтой байдлаар/

### Тайлагналын хувьд:

- Үзүүлэлтүүдээ графикаар болон нарийвчилсан байдлаар уян хатан харуулах,
- Системийн өгөгдлийг татаж авах, харуулах боломжтой байх
- Хэрэглэгч дээр хийсэн өөрчлөлтийн тайлан гардаг байх /эрх нээсэн хаасан өөрчлөлт хийсэн лог/
- UI дээрээс эрхийн бүлгийн жагсаалт болон эрхийн бүлэг доторх үйлдлүүдийн жагсаалтыг татаж авдаг байх, нийт хэрэглэгчийн тайлан гардаг байх
- Хэрэглэгчийн логийн тайлан гардаг байх./Алдаа шалгахад шаардлагатай байдаг/, эрхийн бүлгийн өөрчлөлт лог тайлан гардаг байх.



**ХАВСРАЛТ 3.****Хэрэглэгч талын үндсэн шаардлагууд**

№	Модуль	Дэлгэрэнгүй	Хийгдэх систем
<b>Бүртгэлийн модуль</b>			
1	Систем хэрэглэгчийн бүртгэл	Иргэдийн бүртгэл	Бүртгэлийн веб систем
2		Эцэг эхийн бүртгэл	Бүртгэлийн веб систем
3		Соёл бүтээлч үйлдвэр эрхлэгчдийн бүртгэл	Бүртгэлийн веб систем
4		Нийгмийн ажилтны бүртгэл	Бүртгэлийн веб систем
5		Ангийн багшийн бүртгэл	Бүртгэлийн веб систем
6		Соёлын урлагийн байгууллагуудын угтагч	Бүртгэлийн веб систем
7		Соёлын урлагийн байгууллагын захирал	Бүртгэлийн веб систем
8		Нягтлан бодогч	Бүртгэлийн веб систем
9		Соёлын яамны админ бүртгэл	Бүртгэлийн веб систем
10		Соёлын яамны мэргэжилтэн	Бүртгэлийн веб систем
11	Эрхийн бичиг	Эрхийн бичгийн төрлүүд	Бүртгэлийн веб систем
12		Эрхийн бичгийн төрлүүдийн эзлэх хувь	Бүртгэлийн веб систем
13		Хөтөлбөрүүдийн бүртгэл	Бүртгэлийн веб систем
14		Контент урын сангийн бүртгэл	Бүртгэлийн веб систем
15		Контент урын сангийн категори, төрлүүд	Бүртгэлийн веб систем
16	Соёл урлагийн байгууллагуудын бүртгэл	Соёл урлагийн байгууллагуудын бүртгэл	Бүртгэлийн веб систем
17		Соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгч компани	Бүртгэлийн веб систем
18		21 аймаг, сум байршлууд	Бүртгэлийн веб систем
19		Төрийн байгууллагуудын бүртгэл	Бүртгэлийн веб систем
20		Бусад шаардлагатай бүртгэл	Бүртгэлийн веб систем
21	Системийн хэрэглэгчийн бүртгэл	Шинэ хэрэглэгчээр(хүүхэд, эцэг эх, Соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгч) бүртгүүлэхэд мэйл хаяг болон нууц үг шаардлагатай шалгуурыг жишээ нь, хүчинтэй мэйл формат, нууц үгийн хүчтэй байдал зэргийг хангасан байна.	Иргэдийн апп

22		Шинэ хэрэглэгчийн хувьд аль хэдийн ашиглагдаж байгаа мэйл хаягаар бүртгүүлэхийг оролдвол алдааны мессеж хүлээн авна.	Иргэдийн апп
23		Шинэ хэрэглэгч үйлчилгээний нөхцөлтэй танилцан түүнийг хүлээн зөвшөөрсний дараа бүртгэлийг хийх боломжтой байна.	Иргэдийн апп
24		Анх удаа систем бүртгүүлж нэвтрүүлэх бол аппликэйшний гол гол хэсгүүдэд тайлбар гарч ирэх эсвэл тухайн үйлдлийг алгасах товч гарч ирдэг байна.	Иргэдийн апп
25		Шинэ хэрэглэгчийн хувьд бүртгэлийн алхмыг алхам бүрийг хүүхэд, эцэг эх, Соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгч төрлөөс хамаарч өөр өөр процесстой байх бөгөөд хэрэглэгчийн төрлөөс хамаарсан тодорхой зааварчилгаа бүхий жигд, ойлгомжтой байдлаар харуулна.	Иргэдийн апп
26		Шинэ хэрэглэгчийн өөрийн профайл мэдээлэлд мэйл, зураг, хаяг гэх мэт хувийн мэдээллээ сольж өөрчилдөг байна.	Иргэдийн апп
27		Хэрэглэгч нууц үгээ мартсан тохиолдолд нууц үгээ шинэчлэх боломжтой байна.	Иргэдийн апп
28		Хэрэглэгч өөрийн мэдээллийг идэвхгүй болгодог эсвэл бүүр өөрийн мэдээллийг системээс устгадаг байна.	Иргэдийн апп
29		Хүүхдийн мэдээллийг ДАН системээс автоматаар баталгаажуулдаг байна.	Иргэдийн апп
30		Асран хамгаалагчийн хувьд мөн адил регистрийг оруулах бөгөөд тухайн асран хамгаалагч ямар хүүхдийн мэдээллийг харах эсэхийг УБЕГ-н үйлчилгээ авч таньдаг байна.	Иргэдийн апп
31		Хүүхэд, асран хамгаалагч, СБҮЭ, соёл урлагийн байгууллагууд системээр бүртгүүлэн орж өөрийн профайл буюу хувийн мэдээллийг нэмж, засаж оруулдаг байна.	Иргэд, СБҮЭ-ийн апп
32	Бусад бүртгэл	Систем дээрх түгээмэл асуулт хариулт, үйлчилгээний нөхцөл, нууцлалын бодлого зэргийг динамик байдлаар систем админ оруулдаг байна.	Бүртгэлийн веб систем
33		Систем админ системийн хэрэглэх хэрэглэгчийн гарын авлагыг системд динамикаар оруулдаг байна	Бүртгэлийн веб систем
34		СБҮЭ болон соёл урлагийн байгууллагуудтай хийх гэрээг систем рүү оруулж автомат гэрээ хийдэг байна.	СБҮЭ-ийн апп
35		Систем админ бидний тухай, холбоо барих, гарч болох эрсдэл хэсгийн мэдээллийг мөн адил динамикаар оруулдаг байх.	Бүртгэлийн веб систем
36	<b>Захиалгын модуль</b>		
37	Хүүхэд захиалга хийх модуль	Хэрэглэгчийн хувьд огноо, байршил, төрөл гэх мэт шалгуураар соёлын хөтөлбөр, контентыг хайж олно. Мөн өөр сонирхолтой болон сонирхолгүй контентуудад зүрх дарах эсвэл харагдахгүй болгох боломжтой байдлаар ангилна.	Иргэдийн апп

38	Хэрэглэгчийн өөрийн профайл хэсэгт байршлыг оруулахыг зөвшөөрсөн тохиолдолд байршилтай ойрхон үзвэрүүдийг санал болгож харуулна. Мөн шинэ хөтөлбөрт, контентуудыг мөн адил санал болгож харуулна.	Иргэдийн апп
39	Онлайн платформ болон аппликэйшний бүртгэл үүнд байгууллагын нэр, бизнесийн төрөл, байгууллагын регистрийн дугаар, тусгай зөвшөөрлийн дугаар, тусгай зөвшөөрлийн эхлэх, дуусах огноо, тусгай зөвшөөрөл хүчинтэй эсэх, байгууллагын хаяг, мэйл, утас, веб, захирлын овог нэр гэх мэт.	Иргэдийн апп
40	Хүүхэд хэрэглэгч нь хөтөлбөр, контентын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, тухайлбал арга хэмжээний тайлбар, огноо, цаг, тасалбарын үнэ зэргийг үзэж, оролцох талаар мэдээлэлтэй шийдвэр гаргахад хялбар байдаг байна.	Иргэдийн апп
41	Хэрвээ тухайн контент, үзвэрийг сонгох үед хэрэглэгчийн үлдэгдэл хүрэхгүй бол хэрэглэгч өөрөө нэмэлтээр бусад банкны данс, аппликэйшнээ ашиглаг цэнэглэлтийг хийдэг байна.	Иргэдийн апп
42	Хүүхэд хэрэглэгч нь арга хэмжээнд оролцох тасалбараа захиалсан үед хэрэглэгчийг зөвшөөрсөн эсэхийг давхар асуултаар баталгаажуулан систем хэрэглэгчийн бүртгэлтэй мэйл рүү QR үүсгэн илгээнэ. Энэ QR код нь үзвэр хэрэглэгч бүрд давхардахгүй бөгөөд энэ кодыг Соёлын байгууллага болон үйлчилгээ үзүүлэгч уншуулан үйлчилгээг үзүүлдэг байна. QR үүсгэж илгээгүй тохиолдолд бүртгэлээс дахин үүсгэн илгээх боломжтой байна.	Иргэдийн апп
43	Хэрэглэгч нь өөрийн дуртай суудал эсвэл тасалбарын сонголтоо (жишээ нь, ерөнхий элсэлт, VIP) сонгох боломжтой байна.	Иргэдийн апп
44	Хүүхэд хэрэглэгч үзвэрийг сонгоход эрхийн бичгийн тохиргооноос шалгадаг байна. Жишээ нь дижитал контент 25%, ном 25%, үзвэр үйлчилгээний төлбөр нь нийт төлбөрийн 50%-г эзлэх байдлаар системд контентын төрлөөс хамаарна. Эдгээр хувийг системийн админ тохируулж өгнө.	Иргэдийн апп
45	Хүүхэд хэрэглэгч системийн тохиргоонд хөтөлбөр тус бүрд тохируулан тодорхойлсон өдрөөс хамаарч жишээ нь 3 өдрийн өмнө захиалга цуцалж болно. Захиалгыг цуцлахад цуцлах шалтгааныг оруулна.	Иргэдийн апп
46	Хүүхэд хэрэглэгчийн захиалгын түүхүүдийг нэгтгэн харж чаддаг байна.	Иргэдийн апп
47	Эцэг эхчүүдийн хувьд тухайн хөтөлбөр, контентоос хамаарч захиалга хийх чадамжтай байна.	Иргэдийн апп
48	Эцэг эхчүүдийн хувьд хүүхдийнхээ захиалгыг харах, цуцлах боломжтой байна.	Иргэдийн апп
49	Хэрэглэгч нь үзвэр үйлчилгээнд оролцсоныхоо дараа хөтөлбөр, контентын үйл ажиллагаанд үнэлгээ өгч, дүгнэж, туршлагаа бусадтай хуваалцаж, үндэслэлтэй шийдвэр гаргахад нь тусалдаг байна.	Иргэдийн апп

50		Хэрвээ тухайн хүүхэд өөрөө гар утас ашиглан захиалга хийх боломжгүй бол нийгмийн ажилтан өмнөөс нь бүртгэлийг хийж өгөх боломжтой байна.	Иргэдийн апп
51			
52	<b>Үзвэр үйлчилгээний модуль</b>		
53		Үзвэр үйлчилгээнүүдийг үзвэрийн огноогоор нь эрэмбэлэн хэрэглэгчдэд харуулна. Мөн тухайн үзвэрийг олон нийтийн сүлжээд хуваалцах боломжтой байна.	Иргэдийн апп
54		Үзвэрийн байршил, постер, уран бүтээлч, үнэ, хэдэн хэрэглэгч худалдан авсан, хэдэн хэрэглэгч сонирхсон тоо, хэрэглэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээ зэргийг харуулж хэрэглэгчийг зөв сонголт хийхэд тусална.	Иргэдийн апп
55		Бусад дижитал платформуудыг холбож тухайн платформиос сонголт хийх боломжтой байна.	Иргэдийн апп
56		Нийтийн арга хэмжээ, хөтөлбөрийг ангийн хүүхдүүд нь сонгосон бол хэн хэн сонгосон эсэхийг ангийн багш хардаг байна.	Иргэдийн апп
57		Арга хэмжээний зохион байгуулагч бол СБҮЭ-ийн хувьд худалдаанд гарсан болон гараагүй тасалбарын тоог хардаг. Ирц жигд байгааг хянаж хардаг байна.	СБҮЭ-ийн апп
58		Арга хэмжээ, контентыг харуулахдаа зураг, мультимедиа контент оруулах бол youtube линкийг оруулдаг байна.	Иргэдийн апп
59		Арга хэмжээ, контентын төрлүүдээс оруулсан бүх талбараар хайдаг байна.	Иргэдийн апп
60		Өөрт таалагдсан үзвэрүүдийг таалагдсан гэж сонгосноор дараа нь профайлаас ялган хардаг байна.	Иргэдийн апп
61			
62	<b>Төлбөр тооцооны модуль</b>		
63		Хэрэглэгч өөрийн дансны мэдээллийг систем бүртгүүлдэг байна. Тухайн дансыг тухайн хэрэглэгчийн мөн эсэхийн Cooperate үйлчилгээг ашиглан шалгадаг байна.	Иргэдийн апп
64		Хэрвээ тухайн хэрэглэгчийн дансны дугаар, нэр таарч байвал Соёлын яамны админ хэрэглэгчийн дансыг бөөнөөр цэнэглэдэг байна.	Бүртгэлийн веб систем
65	Төлбөр тооцооны модуль	Системийн админы хувьд хөтөлбөрийн үнэд хөнгөлөлт эдлэх боломжтой байхаар тохируулна. Жишээ нь том хүн үндсэн үнээр үздэг хүүхэд түүнээс буулгасан үнээр үзэж тасалбарын үнийг хямдруулах боломжтой байна.	Бүртгэлийн веб систем
66		Нэгдсэн төлбөр хийгдсэн тохиолдолд хэрэглэгч профайл цэсийн дансны гүйлгээний хуулгыг хардаг байна. Мөн гүйлгээ хийгдсэн үед мэйл болон мэдэгдэл очдог байна.	Иргэдийн апп
67		Хэрвээ хэрэглэгчийн данс цэнэглэгдээгүй ямар нэг алдаа гарсан бол системийн админ руу хүсэлт гаргаж мэдэгддэг байна.	Иргэдийн апп

68		Хэрэглэгч нь хэрвээ тухайн боломжит хугацаанд захиалгаа цуцалсан үед төлбөр буцаан хэрэглэгчийн данс руу орно. Хэрэглэгч дангаараа өөрийн данс рүү гүйлгээ хийх боломжгүй байна.	Иргэдийн апп
69		СБҮЭ болон Соёлын байгууллагын ажилтан төлбөр авах хүсэлтийг Соёлын яамны нягтлан бодогч руу илгээх боломжтой байна. Харин СБҮЭ, соёлын байгууллагын нягтлан бодогч болон иргэд хоёр дансанд байгаа төлбөрөө өөрийн данс руу авах шууд гүйлгээ хийх боломжгүй байна. Заавал Соёлын яамны нягтлан бодогч эрх бүхийн албан тушаалтнаар дамждаг байна.	СБҮЭ-ийн апп
70		СБҮЭ-ийн дансыг мөн эсэхийн Cooperate үйлчилгээг ашиглан шалгадаг байна.	Бүртгэлийн веб систем
71		СБҮЭ өөрийн орлогыг тоо бүрээр харах боловч ямар хэрэглэгч авсан талаарх мэдээллийг хардаггүй байна.	СБҮЭ-ийн апп
72		Соёлын байгууллагын хувьд тасалбарын борлуулалтаас мөн адил ашиг хүртэнэ. Тухайн хөтөлбөр дээр тохируулсан хувиар орлогыг хүртэнэ. Энэ орлогыг Соёлын яамны нягтлан бодогч мөн адил хөтөлбөрийн үзэлтээс хамаарч орлогыг шилжүүлдэг байна.	СБҮЭ-ийн апп
73			
74	<b>Санал асуулга, судалгааны модуль</b>		
75		Хэрэглэгч соёлын арга хэмжээ, үйл ажиллагаанд оролцсоныхоо дараа санал асуулга бөглөж, санал хүсэлтээ өгдөг байна.	Иргэдийн апп
76		Мөн өөрийн туршлагаа олон нийтийн сүлжээнд хуваалцах боломжтой байна.	Иргэдийн апп
77		Хэрэглэгч санал асуулгыг өгөхдөө контент болон үйл ажиллагаа уран бүтээлчдэд мөн түүнийг зохион байгуулсан соёлын байгууллагад(кино театр, үзвэр үйлчилгээ, дэлгүүр гэх мэт) мөн адил өгдөг байна. Санал асуулга өгөхдөө 1-5 оноогоор үнэлж, нэмэлт хүсэлт бичих байдлаар хялбар саналаа өгдөг байна.	Иргэдийн апп
78		Хэрэглэгч нь хөтөлбөр, контент сонгохоосоо өмнө санал асуулгын нэгдсэн үр дүнг (жишээ нь, ерөнхий үнэлгээ, сэтгэгдэл) харах боломжтой байна.	Иргэдийн апп
79		СБҮЭ мөн адил түүний уран бүтээлийг зохион байгуулсан газарт саналаа өгдөг байна.	СБҮЭ-ийн апп
80		Зохион байгуулагч газар, соёл урлагийн байгууллага мөн адил СБҮЭ-дэд санал үнэлгээ өгдөг байна.	СБҮЭ-ийн апп
81		Соёлын яамны мэргэжилтэн бага үнэлгээтэй СБҮЭ болон газар зохион байгуулсан байгууллагад сануулга өгдөг мөн өгсөн сануулгыг систем дээр авсан арга хэмжээгээ бүртгэдэг байна. Мөн шаардлагатай гэж үзвэл СБҮЭ-ийг хар жагсаалтад оруулдаг байна.	Бүртгэлийн веб систем
82		Соёлын яамны мэргэжилтэн нь хөтөлбөр, контент шинээр оруулахаасаа өмнө санал асуулгын нэгдсэн үр дүнг хардаг байна.	Бүртгэлийн веб систем

83		Хэрэглэгчээс ирсэн санал хүсэлтийг Соёлын яамны мэргэжилтэн рүү илгээдэг байна. Мэргэжилтэн хүлээн авч шийдвэрлэдэг, хэрхэн шийдвэрлэсэн түүх үлддэг байна.	Иргэд, СБҮЭ-ийн апп
84	<b>Мэдэгдлийн модуль</b>		
85	Мэдэгдлийн модуль	Хэрэглэгч нь өөрийн сонирхол, байршилд тулгуурлан удахгүй болох соёлын арга хэмжээ, арга хэмжээний талаар мэдэгдлийг цаг алдахгүй хүлээн авдаг байна.	Иргэдийн апп
86		Асран хамгаалагч, багш нар хүүхэд ямар нэг сонголт захиалсан үед мэдэгдэл хүлээн авна.	Иргэдийн апп
87		Хэрэглэгчийн цахим данс цэнэглэгдэх үед мэдэгдэл хүлээн авна.	Иргэдийн апп
88		Соёлын бүтээлч үйлдвэрлэгч захиалга бүртгэх, цуцлах үед мэдэгдэл хүлээн авна.	СБҮЭ-ийн апп
89		Соёлын бүтээлч үйлдвэрлэгч төлбөр тооцоо хийгдэж данс руу мөнгө шилжсэн үед мэдэгдэл хүлээн авна.	СБҮЭ-ийн апп
90		Соёлын яамны мэргэжилтэн, систем админ системийн хэрэглэгчийн төрлийг сонгон мэдэгдэл илгээдэг байх	Бүртгэлийн веб систем
91	<b>Хайлт шүүлт, тайлагналын модуль</b>		
92		Систем дээрх түгээмэл асуулт хариулт, үйлчилгээний нөхцөл, нууцлалын бодлого зэргийг динамик байдлаар систем админ оруулдаг байна.	Бүртгэлийн веб систем
93	Админ тайлагнал	Админ хөтөлбөр, контент, захиалга үзэлтүүдийг 21 аймаг, сум, байршил, нас, хүйс гэх мэт хүн ам зүйн хүчин зүйлээр ялган харж жигд тархалттай байгаа эсэхийг тайлангаар хардаг байна.	Бүртгэлийн веб систем
94		Системийн админ нь систем дээрх хэрэглэгчийн тоо, захиалга, төлбөр тооцоог бодит цагийн боломжоор шууд хардаг байна.	Бүртгэлийн веб систем
95		Системийн админ хамгийн их үзэлттэй хөтөлбөр, худалдан авалтыг тайлан байдлаар хардаг байна.	Бүртгэлийн веб систем
96		Системийн админ нь соёлын арга хэмжээ, арга хэмжээний талаар хэрэглэгчийн санал хүсэлт, шүүмжийг хянах чадвартай байна. Ингэснээр сайжруулах шаардлагатай байгууллага, СБҮЭ зэргийг тодорхойлж, хэрэглэгчдийн саналт хүсэлтийг шийдвэрлэх боломжтой болно.	Бүртгэлийн веб систем
97		Соёлын байгууллагын өөрийн зохион байгуулсан бүхий л төрлийн хөтөлбөр, арга хэмжээнд оролцогчдын ирц, оролцооны талаарх аналитик мэдээллийг харж, санал болгож буй саналынхаа амжилтыг үнэлж, цаашдын арга хэмжээг төлөвлөх боломжтой байна.	СБҮЭ-ийн апп
98		СБҮЭ-ийн өөрийн контент, хөтөлбөрийн бүхий л төрлийн хөтөлбөр, арга хэмжээнд оролцогчдын ирц, оролцооны талаарх аналитик мэдээллийг харж, санал болгож буй саналынхаа амжилтыг үнэлж, цаашдын арга хэмжээг төлөвлөх боломжтой байна.	СБҮЭ-ийн апп
99		Системийн админ нь хэрэглэгчийн зан төлөвийг харуулсан тайлангуудыг хардаг байна.	Бүртгэлийн веб систем

100	Хэрэглэгч тайлагнал	Биелсэн болон идэвхтэй захиалгуудыг харах	Иргэд, СБҮЭ-ийн апп
101		Сэтгэл ханамжийн үнэлгээнүүдийг харах	Иргэд, СБҮЭ-ийн апп
102		Дуртай гэж тэмдэглэсэн хөтөлбөр, контентуудыг харах	Иргэдийн апп
103		Дансны орлого зарлагыг ялгаж хардаг байна.	Иргэд, СБҮЭ-ийн апп
104		Ямар төрлийн төлбөр сонгох боломжтой эсэхийг ойлгомжтой ялгаж хардаг байна. Жишээ нь дижитал контент 25%, ном 25%, үзвэр 50% гэх мэт. Одоо аль төрлийн контентыг үзэх дутуу гэх мэт.	Иргэдийн апп
105		Өөрийн бүртгэлтэй банк, дансны дугаарыг харах	Иргэд, СБҮЭ-ийн апп
106		Өөрт ирсэн мэдэгдлүүдийг харах	Иргэд, СБҮЭ-ийн апп